| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт   | Тайлант оны           |                  |
|-----------------------|--|-----------------------|------------------|
|                       |  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл        |
| <b>1</b>              | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>          |                       |                  |
| <b>2</b>              | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                         | 1,113,931,600.00      | 1,110,566,863.00 |
| <b>21</b>             | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | 1,113,931,600.00      | 1,110,566,863.00 |
| <b>210</b>            | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                           | 1,080,877,300.00      | 1,077,522,063.00 |
| <b>2101</b>           | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                         | 726,743,600.00        | 726,742,181.54   |
| 210101                | Үндсэн цалин   | 545,965,200.00        | 514,505,327.76   |
| 210102                | Нэмэгдэл   | 153,615,100.00        | 185,073,553.78   |
| 210103                | Унаа хоолны хөнгөлөлт  | 27,163,300.00         | 27,163,300.00    |
| <b>2102</b>           | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>            | 97,414,600.00         | 97,414,600.00    |
| 210201                | Тэтгэврийн даатгал   | 68,828,800.00         | 68,562,300.00    |
| 210202                | Тэтгэмжийн даатгал   | 7,146,300.00          | 7,412,800.00     |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал  | 5,717,200.00          | 5,717,200.00     |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал   | 1,429,400.00          | 1,429,400.00     |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал  | 14,292,900.00         | 14,292,900.00    |
| <b>2103</b>           | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                 | 84,324,700.00         | 84,321,689.00    |
| 210301                | Гэрэл, цахилгаан   | 32,078,200.00         | 32,078,200.00    |
| 210302                | Түлш, халаалт  | 24,534,400.00         | 25,800,944.00    |
| 210303                | Цэвэр, бохир ус  | 27,712,100.00         | 26,442,545.00    |
| <b>2104</b>           | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                          | 33,245,100.00         | 32,915,077.10    |
| 210401                | Бичиг хэрэг  | 4,338,900.00          | 4,296,300.00     |
| 210402                | Тээвэр, шатахуун   | 3,961,100.00          | 3,817,100.00     |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                               | 3,747,800.00          | 3,622,797.10     |
| 210405                | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал        | 200,000.00            | 181,600.00       |
| 210406                | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                      | 20,997,300.00         | 20,997,280.00    |
| <b>2105</b>           | <b>Нормативт зардал</b>  | 87,521,500.00         | 84,395,320.05    |
| 210501                | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                  | 1,473,000.00          | 1,405,800.00     |
| 210502                | Хоол, хүнс   | 79,747,500.00         | 76,990,420.05    |
| 210503                | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                      | 6,301,000.00          | 5,999,100.00     |
| <b>2106</b>           | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                         | 6,559,000.00          | 6,559,000.00     |
| 210601                | Багаж, техник, хэрэгсэл  | 6,559,000.00          | 6,559,000.00     |
| <b>2107</b>           | <b>Томилолт, зочны зардал</b>                                    | 1,463,000.00          | 1,448,000.00     |
| 210702                | Дотоод албан томилолт  | 1,463,000.00          | 1,448,000.00     |
| <b>2108</b>           | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | 43,605,800.00         | 43,517,036.40    |
| 210801                | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хур | 40,942,900.00         | 40,937,136.40    |
| 210802                | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                         | 720,000.00            | 720,000.00       |
| 210803                | Даатгалын үйлчилгээ  | 600,000.00            | 591,500.00       |
| 210804                | Тээврийн хэрэгслийн татвар                                       | 50,000.00             | 42,500.00        |
| 210805                | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                    | 100,000.00            | 33,000.00        |
| 210806                | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                  | 875,800.00            | 875,800.00       |
| 210807                | Газрын төлбөр  | 317,100.00            | 317,100.00       |
| <b>213</b>            | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | 33,054,300.00         | 33,044,800.00    |
| <b>2132</b>           | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                    | 33,054,300.00         | 33,044,800.00    |
| 213205                | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                         | 31,594,800.00         | -                |
| 213207                | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж              | -                     | 31,594,800.00    |
| 213209                | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                          | 1,459,500.00          | 1,450,000.00     |
| 213503                | Төвлөрүүлэх шилжүүлэг  |                       | 209,158.91       |
|                       | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                            | 1,113,931,600.00      | 1,110,541,500.00 |
| <b>1310</b>           | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                   | 1,036,482,500.00      | 1,036,482,500.00 |
| <b>131001</b>         | <b>Улсын төсвөөс санхүүжих</b>                                   | 1,036,482,500.00      | 1,036,482,500.00 |
| <b>120004</b>         | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                     |                       |                  |
| 1200042               | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                        | 77,449,100.00         | 74,059,000.00    |
| <b>4</b>              | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>          | -                     | -                |
| <b>5</b>              | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>         | -                     | 5,100,000.00     |
| <b>62</b>             | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>  | 64.00                 | 64.00            |
| 620001                | Удирдах ажилтан  | 1.00                  | 1.00             |
| 620002                | Гүйцэтгэх ажилтан  | 53.00                 | 53.00            |
| 620003                | Үйлчлэх ажилтан  | 10.00                 | 10.00            |
| 620004                | Гэрээт ажилтан   | -                     | -                |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх он              | Гүйцэтгэл             |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>  | <b>177,666,563.00</b> | <b>146,393,582.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>175,525,713.00</b> | <b>146,392,892.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | 173,731,713.00        | 140,892,892.00        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>  | 40,319,918.00         | 43,280,137.00         |
| 210101      | Үндсэн цалин  | 40,319,918.00         | 43,280,137.00         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>   | 4,716,305.00          | 2,377,961.00          |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 4,716,305.00          | 2,377,961.00          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | 12,212,777.00         | 11,521,965.00         |
| 210401      | Бичиг хэрэг   | 3,117,719.00          | 3,298,465.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 8,006,058.00          | 6,123,500.00          |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр  | 665,000.00            | 1,740,000.00          |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс   | 424,000.00            | 360,000.00            |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | 11,857,650.00         | 5,450,000.00          |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл   | 11,857,650.00         | 5,450,000.00          |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>   | 8,023,600.00          | 2,520,000.00          |
| 210702      | Дотоод албан томилолт   | 8,023,600.00          | 2,520,000.00          |
| 210703      | Зочин төлөөлөгч хүлээн авах   | -                     | -                     |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>   | 47,576,630.00         | 11,550,000.00         |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж  | 46,586,630.00         | 7,050,000.00          |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ   | 990,000.00            | 4,500,000.00          |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>  | 49,024,833.00         | 64,192,829.00         |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал   | 41,838,883.00         | 64,192,829.00         |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх   | 7,185,950.00          | -                     |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | 1,794,000.00          | 5,500,000.00          |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>   | 1,794,000.00          | 5,500,000.00          |
| 213205      | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал  | 1,794,000.00          | 5,500,000.00          |
| <b>2133</b> | <b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>  | <b>2,140,850.00</b>   | <b>690.00</b>         |
| 213305      | Нэмэлт санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг  | 158,850.00            | 690.00                |
| 213503      | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг  | 1,982,000.00          |                       |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>   | <b>177,666,693.00</b> | <b>146,393,582.00</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | 177,666,693.00        | 146,393,582.00        |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж   | 45,865,563.00         | 36,916,242.00         |
| 131103      | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 101,361,450.00        | 72,735,290.00         |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө  | 30,439,680.00         | 13,427,000.00         |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                |                       | 23,315,050.00         |
| <b>IV</b>   | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>   |                       |                       |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | -                     | -                     |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл   | -                     | -                     |

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг Н.Мөнхгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 15–ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дэлгэрмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 1/37 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- “Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын зорилго оршино.”

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд харьяа орон нутаг дахь Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 1,961,681.9 төгрөгөөс 2 хувиар тооцон 39,233.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,718,955.5 мянган төгрөгөөр буюу 55.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт           |
|---|--------------------|--------------------|--------------------|
| Б   | 1                  | 2                  | 3=2-1              |
| Мөнгөн хөрөнгө                                    |                    | 5,100.0            | 5,100.0            |
| Авлага  |                    | 1,420.2            | 1,420.2            |
| Урьдчилгаа  |                    |                    |                    |
| Бараа материал                                    | 52,112.4           | 31,968.4           | -20,144.0          |
| Үндсэн хөрөнгө                                    | 2,892,881.8        | 6,625,461.1        | 3,732,579.3        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>2,944,994.2</b> | <b>6,663,949.7</b> | <b>3,718,955.5</b> |
| Өр төлбөр   |                    | 1,420.2            | 1,420.2            |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 2,944,994.2        | 6,662,529.5        | 3,717,535.3        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>2,944,994.2</b> | <b>6,663,949.7</b> | <b>3,718,955.5</b> |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 5,100.0 мянган төгрөг байна. Энэ нь ахмадын сангийн дансны үлдэгдэл төрийн сантай дансны үлдэгдлийг баталгаажуулсан байна.

Авлага, өглөгийн дансны үлдэгдэл 1,420.2 мянган төгрөг болсон нь хөгжлийн бэрхшээлтэй 5 ажилтны цалингийн орлогоос ХХОАТ-ыг суутган авч шилжүүлсэн бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажуулан авлага, өглөгөөр бүртгээгүй байсан тул санхүүгийн тайлангаар авлага, өглөг үүсгүүлсэн.

Бараа материалын дансны үлдэгдэл 31,968.4 мянган төгрөг болж 20,144.0 мянган төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материал буурснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,625,461.1 мянган төгрөг болж 3,732,579.3 мянган төгрөгөөр өссөн нь барилга байгууламж, бусад үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 12,084.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 4,407,431.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 612,491.8 мянган төгрөг, акталсан 84,262.6 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 7,820.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,662,529.5 мянган төгрөг болж 3,717,535.3 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалт нэмэгдсэнээс шалтгаалсан байна

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3,980,127.8 мянган төгрөгөөр буюу 234.2 хувиар өссөн байна

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого байна. Энэ нь Хүний хөгжлийн ордны барилга, Хэрлэн сумын 4 дүгээр багт байрлах Хүний хөгжлийн ордон руу тавигдсан авто зам зэрэг хөрөнгийг орлогдсон байна.

Нийт зардал өмнөх оноос 152,723.0 мянган төгрөгөөр буюу 10.7 хувиар өссөн байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,207,008.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,207,008.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 78,095.8 мянган төгрөгөөр бууруулж 1,128,912.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,128,912.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,051,463.7 мянган төгрөгийг улсын төсвөөс 77,449.1 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,049,632.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 74,059.0 мянган төгрөг, нийт 1,123,691.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,123,482.3 мянган төгрөгийг зарцуулж 209.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,123,482.3 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Орон нутгийн төсөвт 2020 онд 77,449.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 74,059.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 95.6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

| Орлогын төрөл                     | Төлөв           | Гүйц            | Зөрүү          | Хувь        |
|-----------------------------------|-----------------|-----------------|----------------|-------------|
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 77,449.1        | 74,059.0        | 3,390.1        | 95.6        |
| <b>Нийт дүн</b>                   | <b>77,449.1</b> | <b>74,059.0</b> | <b>3,390.1</b> | <b>95.6</b> |

## Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 109,651.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 13,427.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 23,315.0 мянга төгрөг, нийт 146,393.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалинд 45,658.1 мянган төгрөг, хангамж бараа материалд 11,521.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал зардалд 5,450.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 83,762.9 мянган төгрөг нийт 146,392.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 0.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 133 мэдээлэл, 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8,070.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,420.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,650.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,840.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 4,810.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Хөгжлийн бэрхшээлтэй 5 ажилтны цалингийн орлогоос нийт 1,420.2 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган авч шилжүүлсэн бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажуулан авлага, өглөгөөр бүртгээгүй тул санхүүгийн тайланд засуулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 6,650.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,840.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 4,810.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант оны эцэст 1,840,418 төгрөгийн хүнс, түлш, шатах тослох материал нөөцөлсөн нь Төсвийн тухай хуулийн 43.5 дахь "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байдал, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант жилд үндсэн үйл ажиллагаанаас 77,449.1 мянган төгрөгийн орлого оруулахаар төлөвлөж 74,059.0 мянган төгрөгийн орлого орж төсвийн орлого 3,390.1 мянган төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41.2 дахь “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1 дахь “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй, хэмжилт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Цалингийн зардалд дахин тооцоолол хийж шалгах явцад Хөгжлийн бэрхшээлтэй 5 ажилтнаас 1,420,236.0 төгрөгийн хүн амын орлогын албан татвар суутган тооцсон нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1 дэх “дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2 дахь “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18.1.1 дэх “хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ...” гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 1 зөрчилд зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Байхгүй.

#### **4. Менежментийн захидал**

---

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### *Дотоод хяналттай холбоотой асуудал*

- 1.1. Илрүүлэлт: Шилэн дансанд байршуулсан мэдээллийг ерөнхий журнал болон анхан шатны санхүүгийн мэдээ тайлангуудтай тулгахад 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.
- 1.2. Эрсдэл: Хууль журам хэрэгжихгүй байх, мэдээллийн ач холбогдол буурах.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

|        |              |  |                      |
|--------|--------------|--|----------------------|
| Огноо: | Аудитын нэр: | <i>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i> | Аудитын код:         |
| 2020   |              |  | ДОА-2021/117/СТА-ТШЗ |

|                              |   |               |
|------------------------------|---|---------------|
| Шалгагдсан байгууллагын нэр: | <i>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар</i> | Мянган төгрөг |
|------------------------------|---|---------------|

| №          | Алдаа, зөрчлийн товч утга  | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны |                           |
|------------|--|------------|---------------------------------------|---|---------------------------|
|            |  |            | Нэр                                   | Албан тушаал                                      | Овог нэр                  |
|            | 1  | 2          | 3                                     | 4   | 5                         |
| 1          | Тайлант оны эцэст 1,840,418 төгрөгийн хүнс, түлш, шатах тослох материал нөөцөлсөн байна.   | 1,840.4    | Төлбөрийн акт                         | Дарга, Нягтлан бодогч                             | Н.Мөнхгэрэл Х.Сарандагина |
| 2          | Тайлант жилд үндсэн үйл ажиллагаанаас 77,449.1 мянган төгрөгийн орлого оруулахаар төлөвлөж 74,059.0 мянган төгрөгийн орлого орж төсвийн орлого 3,390.1 мянган төгрөгөөр тасарсан байна.            | 3,390.1    | Албан шаардлага                       | Дарга, Нягтлан бодогч                             | Н.Мөнхгэрэл Х.Сарандагина |
| 3          | Хөгжлийн бэрхшээлтэй 5 ажилтнаас 1,420,236.0 төгрөгийн хүн амын орлогын албан татвар суутган тооцсон.  | 1,420.2    | Албан шаардлага                       | Дарга, Нягтлан бодогч                             | Н.Мөнхгэрэл Х.Сарандагина |
| 4          | Шилэн дансанд байршуулсан мэдээллийг ерөнхий журнал болон анхан шатны санхүүгийн мэдээ тайлангуудтай тулгахад 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.                                     | 0.0        | Зөвлөмж                               | Дарга, Нягтлан бодогч                             | Н.Мөнхгэрэл Х.Сарандагина |
| 5          | Хөгжлийн бэрхшээлтэй 5 ажилтны цалингийн орлогоос нийт 1,420,236.0 төгрөгийн ХХОАТ-ыг суутган авч шилжүүлсэн байгаа бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажуулан авлага, өглөгөөр бүртгээгүй байна. | 1,420.2    | Өр, авлага үүсгүүлж залруулсан        | Дарга, Нягтлан бодогч                             | Н.Мөнхгэрэл Х.Сарандагина |
| <b>ДҮН</b> |  | 8,070.9    |                                       |   |                           |

